



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/130.

Мандалговь

Гамшгаас хамгаалах сургууль, үзлэгийг
зохион байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13.3.2, 32.1.1, 51.4 дэх заалт, Монгол Улсын Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь хэсэг, аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2019 оны үндсэн чиглэлд заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гамшгаас хамгаалах удирдах бүрэлдэхүүний команд штабын дадлага сургуулийг Гурвансайхан, Эрдэнэдалай сумдад 2019 оны 3 дугаар сарын 25-29-ны өдрүүдэд, Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг Говь-Угтаал, Сайхан-Овоо, Өлзийт сумдад 2019 оны 4 дүгээр сарын 1-7-ны өдрүүдэд, Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг Өндөршил суманд 2019 оны 4 дүгээр сарын 8-10-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсугай.

Хоёр. Гамшгаас хамгаалах сургууль, үзлэгийг батлагдсан бодлого, төлөвлөгөө, удирдамжийн дагуу явуулж дүнг 2019 оны 4 дүгээр сарын 15-ны дотор танилцуулахыг сургуулийн удирдагч (Дэд хурандаа М.Адъяабаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190333